

Зүй зохистой байх

Цар тахал, хурц халдварт өвчин бол түүхийн явцад зайлшгүй гардаг Бурхны нэг зохицуулалт юм. Хүмүүс ухамсар, ёс суртахуунаа алдахад их хэмжээний нүгэл хураадаг, өвчин тусдаг, гай гамшигт нэрвэгддэг. Ийм нөхцөлд Бурханд итгэдэггүй хүмүүс янз бүрийн "арга хэмжээ" (цуо-ши) авдаг. Гэхдээ "цуо-ши" гэдэг үг нь Хятадаар "буруу хандлага" гэсэн өөр нэг утгатай. Түүх бидэнд олон тустай сургамж үлдээсэн боловч Хятадын харгис Коммунист Намын шашингүйн үзлээр тархиа угаалгаж Бурханд сүсэггүй болсон өнөөгийн Хятад хүмүүс түүхийн сургамжинд итгэдэггүй.

Чухамдаа, цар тахал гарах шалтгаан нь хүмүүсийн ухамсар, ёс суртахуун үлэмж ихээр доройтож асар их хэмжээний нүгэл хуримтлагдсантай холбоотой юм. Хэрэв цар тахал нь Бурханы зохицуулалт юм бол, Бурханы зорилгоос үүдэн гардаг бол яаж зогсоох вэ? Зарим хүмүүс уг шалтгааныг ухамсарлаж Бурханд залбирч аврал гуйдаг, гэхдээ энэ нь туслахгүй байж мэднэ. Яагаад гэвэл хүмүүсийн ухамсар, ёс суртахуун доройтож, хийсэн нүгэл нь асар их болсон учраас устгагдах ёстой болсон, тэгвэл Бурхан ямар учраас хамгаалах юм? Түүний оронд хүмүүс Бурханд чин сэтгэлээсээ нүглээ наминчлан залбирч, буруугаа засах сүүлчийн боломж олгохыг гуйх хэрэгтэй. Энэ бол зовлонгоосоо ангижрах цорын ганц зам.

Гэхдээ одоо гарсан Хятадын коммунизмын вирус ("Ухань корона вирус") тахал нь цаанаа учир, шалтгаантай: Энэ нь бурангуй намыг дагагчдыг, түүний талыг баримтлагчдыг устгахад чиглэсэн юм. Хэрэв үүнд итгэхгүй байвал одоо ямар улс орон хамгийн их нэрвэгдэж байгаагаас харж болно: Энэ нь ХКН-тай ойр дотны түншүүд юм, хүмүүсийн хувьд мөн адил. Тэгвэл яах ёстой вэ? Хятадын харгис Коммунист Нам-аас хол бай, түүний гар хөл болдгоо болих хэрэгтэй. Яагаад гэвэл түүний ард улаан ад чөтгөр бий, гаднаа харагдах байдал, үйлдэл нь танхай балмад, ямарч харгислал үйлдэхээс буцахгүй. Тиймээс одоо Бурханд үүнийг устгаж эхэлж байна, энэ талд зогсогчид бүгд устана. Үүнд эргэлзэж байвал түр хүлээ, тэгээд үзэх болно.

Зарим идэвхи зүтгэл гаргадаггүй, эсвэл хэт туйлширсан (сөрөг нөлөө үзүүлж байгаа) Дафа сурагчид энэ байдлаа нэн даруй зас, чин сэтгэлээсээ Фа унш, сайн бясалга, учир нь тийм сурагчид их эрсдэлтэй. Жинхэнэ Дафаг-ийн шавь нар бүгд карма, нянг устгах хүчтэй энерги, чадвартай. Тэд бол эцсийн сүйрлийн үеийн авралын элч, хүмүүст үнэнийг таниулж зүй зохистойгоор аварч байгаа. Харин одоо зарим газрын сурагчид Хятадын коммунизмын вирусыг (Ухань корона вирус) зогсоохын тулд ариусгалын бодол гаргахыг хамтдаа хийцгээе гэж нэг нэгэндээ уриалж байна. Энэ бол зөв санаа биш. Та нар энд түүхийг өөрчлөхийн төлөө биш, харин түүхэн дэх үхлийн аюултай энэ цаг үед хүмүүсийг аврах зорилготой байгаа. Хүмүүст үнэнийг ойлгуулах, ХКН-ын харъяа гурван байгууллагаас гарахад нь туслах, чин сэтгэлээсээ гайхамшигт үгнүүдийг¹ хэлж байхыг зөвлөх нь хүмүүсийг аврах хамгийн шилдэг арга зам мөн. Хүмүүсийн ухамсар, ёс суртахуун эергээр өөрчлөгдвөл бүх зүйл сайнаар эргэнэ. ХКН устгагдах эцсийн хямралд орохдоо нийгэмд эмх замбараагүй байдал дэгдээж хүмүүст улам их хор хөнөөл учруулж байна. Дафа-гийн шавь нар энэ эмх замбараагүй байдалд барьц алдаж болохгүй, бат суурьтай байвал энэ үймээний учир байдал нь тодорхой харагдана.

Ли Хонжи
2020 оны 3-р сарын 19

¹ "Фалунь Дафа хао" мөн "Жэнь, Шань, Рэн хао" гэсэн уншлага.